



Ц.Оюун, доктор (Sc.D), профессор,
НХУС-ийн Монгол хэлний тэнхимийн зөвлөх профессор
Ж.Янжинлхам, магистр, НХУС-ийн багш

ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭЛ НАЙРУУЛГА

Резюме: Научно - исследовательские работы хоть и разнятся в кругу преподавателей, научных работников, а также докторов, магистрантов и студентов, однако требования к научным работам остаются едиными. Курсовые и дипломные работы бакалавров попадают в разряд научных работ, поскольку основаны на исследовательских изысканиях, поиске новых вопросов, решении и доказательствах. Поэтому один из важнейших обязанностей преподавателя является удаление внимания к стилистике научных работ, как одной из важнейших направлений требования, предъявляемых к научным и дипломным работам студентов.

Статья адресована к студентам, пишущим научные работы, а также молодым преподавателям, которые впервые руководящим дипломными работами.

Вначале нами даются обоснованные объяснения о важности стилистических требований в научных исследовательских работах. Так же рассмотрены вопросы о том, как студенты должны учитывать особенности стилистики в научных работах, а также требований к ним. Также даются рекомендации, как должны в содержании научных работ студентов причинно-следственная связь, логическая последовательность изложения. Здесь конкретно рассмотрены закон сравнения, закон без конфликтности, закон отрицания, закон достаточного обоснования, требования ясности и точности.

Другой целью статьи является рекомендация молодым преподавателям, впервые руководящим дипломными работами студентов, обратить внимание на стилистику их научных работ, подтягивать ее до требуемого

уровня.

Түлхүүр үг: Шинжлэх ухааны хэл, учир шалтгааны дараалалтай байх шаардлага, логикийн хуульд нийцэх, үгийн сан-хэлзүйн онцлог

Их, дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил багш, эрдэм шинжилгээний ажилтан болон докторант, магистрант, оюутны хүрээнд ялгаатай ч эрдэм шинжилгээний ажилд тавих шаардлагаараа адил юм. Учир нь, судалгааны эрэл хайлтад суурилан, шинэ асуудлыг олж харж шийдэн, баталж нотолдгоороо бакалаврын дипломын болон ангийн ажил эрдэм шинжилгээний ажлын ангилалд багтдаг. Энэ өгүүлээ бид эрдэм шинжилгээний ажил хийх, дипломын ажил бичих оюутан болон ийм ажлыг анх удаа удирдах гэж байгаа залуу багш нарт зориулан бичиж байна.

Оюутны эрдэм шинжилгээний ажил ангийн ажлаас эхлэлтэй. Судалгааны сэдэв сонгон авч удирдагч багшийн чиглүүлэгтэйгээр ангийн ажлаа сайн гүйцэтгэсэн, цааш судалгаа хийх чадамжтай оюутан төгсөх ангидаа түүнийгээ бакалаврын дипломын ажил болгон өргөжүүлж, хамгаалж болдог. Эрдэм шинжилгээний ажил хийх, бакалаврын дипломын ажил гүйцэтгэх оюутан эхний хэмжээнд дараах нийтлэг зарчимд анхаарвал зохино. Үүнд:

1. Бие даан судалгаа хийж мэдлэгээ гүнзгийрүүлсэн оюутанд эрдэм шинжилгээ судалгааны чиглэлтэй нийтлэл, бүтээл гаргах эрх нь нээлттэй.
2. Эрдэм шинжилгээний ажил хийх оюутан судлах сэдвээрээ мэдлэг, чадвар хуримтлуулан ажиглалт, судалгаа, эрэл хайгуулын үндсэн дээр тодорхой асуудлыг олж харж, шинэ

санаа дэвшүүлэн шийдвэрлэх ур чадвар, бэлтгэлтэй болсон байх.

3. Эрдэм шинжилгээний удирдагчийн зөвлөмжөөр бие даан бүтээлч ажиллаж, судалгааны арга зүйд богино хугацаанд суралцах.
4. Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, бүтээл нь бакалаврын дипломын ажлын болон эрдэм шинжилгээний бүтээлд тавих шаардлагыг бүрэн дүүрэн хангах, онол, практикийн шийдэл бүхий байна.
5. Бакалаврын дипломын ажил бичихдээ эрдэм шинжилгээний ажлын ёс зүй, соёлыг сайтар баримталсан байх учиртай.
6. Эрдэм шинжилгээний ажлынхаа зарим хэсгээр өгүүлэл бичиж нийтлүүлэн, илтгэл тавьж хэлэлцүүлж байх зэрэг олон зүйл хамаарна.

Бакалаврын чанартай сайн ажил, магистрын дипломын ажил нь докторын диссертацийн суурь болдог, иймд нэгэнт эхэлсэн ангийн ажил, дипломын ажлын сэдэв, судалгааг чухалчлах учиртай. Мөн зохиол бүтээлд дэвшүүлсэн санаагаа бусдад ойлгомжтой хүргэх бичлэгийн хэл найруулгыг эрхэмлэвэл зохино. Энэ үүднээс бид оюутны хийж гүйцэтгэх эрдэм шинжилгээний найруулгын онцлог, түүнд тавих шаардлагын тухайд дараах саналыг нэмэрлэж байна.

Нэг. Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд хэл найруулга чухал болох нь

Хүн төрөлхтөний хэл нь танин мэдэхүйн хэрэглүүр болохын зэрэгцээ бүх шинжлэх ухааны ухагдахууныг нэршүүлэн тэмдэглэдэг дохио, тэмдгийн тогтолцоо болж байдаг. Учир нь аливаа шинжлэх ухаан ертөнцийн юмс үзэгдлийн мөн чанарыг өөр өөрийн байр сууринаас судлан тайлбарлахдаа хэлээр дамжуулдаг. Иймд шинжлэх ухааны хэлийг эзэмших явц нь ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн тусгай боловсрол, магистрантур, докторантурын шатлалд тасралтгүй үргэлжлэх цогц үйл байдаг.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх хүн ойлгох стратеги, логик ухааралд суралцахын зэрэгцээ шинжлэх ухааны бие биеэ нөхөж болох төсөөг олж харж, ашиглаж чаддаг байх нь чухал. Мөн нэрлэж буй юмсын агуулга, дотоод мөн чанарыг утгачлан, учир шалтгааны үүднээс товч тодорхой, хамгийн ойлгомжтойгоор тайлбарлан

бичих, ярих, тухайн шинжлэх ухааны онцлог, шинжлэх ухааны хэлний хэрэглээ, хүртэгдэх талыг сайтар ухаарах явдал хамгаас эрхэм юм. Учир нь, энэ бүхэн бүтээлийн чанар чансаа, хүнд хүрэх талыг зохистой хэмжээнд хүргэдэг хүчин зүйл мөн.

Хоёр. Эрдэм шинжилгээний найруулгын онцлогийг хадгалах нь

Шинжлэх ухааны салбарт үйлчилж, мэдлэг дамжуулах үүрэгтэй найруулгын төрлийг эрдэм шинжилгээний хэл найруулга гэдэг. Эрдэм шинжилгээний найруулга нь бичгээр илрэхдээ судалгааны өгүүлэл, автореферат, диссертаци, ном зохиолын хэлбэр бүхий утга зохиолын бичгийн найруулгыг, харин аман яриагаар илэрхийлэх үед эрдэм шинжилгээний илтгэл, лекц, сурталчилгаа, тайлбар, мэтгэлцээн зэрэг утга зохиолын аман найруулгыг эрхэмлэдэг тус тусын онцлогтой.

Найруулгын энэ төрөлд шинжлэх ухааны олон салбараар гарч байгаа өгүүлэл, илтгэл, шүүмж, тэмдэглэл, мэдээлэл, гарын авлага, бүтээлд өгөх санал, шинжлэх ухааны чиглэл бүхий лекц, шинжлэх ухааны сэдвээр бичсэн дипломын болон ангийн ажил, ярианы сэдэв болон сургалт заах арга зүйн зөвлөмж, гарын авлага, товхимол, сурах бичиг, боловсролын стандарт, хичээлийн хөтөлбөр, эрдмийн зэрэг горилсон зохиол, зохиолын хураангуй, нэг сэдэвт зохиол зэргийн найруулгыг багтаан үзнэ.

Эрдэм шинжилгээний хэл найруулгыг үндсэнд нь шинжлэх ухааны, шинжлэх ухааны хялбаршуулсан зохиолын найруулга хэмээн ангилна. Шинжлэх ухааны найруулгыг тухайн шинжлэх ухааны салбарыг сайтар мэдэх хүмүүс, судлаачдад зориулсан байдаг бол шинжлэх ухааны нийтлэг зохиол (*хялбаршуулсан зохиол*)-ыг өргөн олонд зориулсан байх тул агуулгын хүрээ, хэл найруулгын хувьд шинжлэх ухааны ухагдахууныг бүхий л хүн ойлгохоор энгийн аргаар тайлбарлах ёстой. Найруулгын энэ төрөлд сурах бичиг, ном товхимол, өгүүлэл, лекц зэрэг орно. Ийм зохиолуудад зураг, схем, бүдүүвч, дүйлгэн тайлбарласан нэр томьёо их хэрэглэгддэг.

Эрдэм шинжилгээний найруулга нь найруулгын бусад төрлөөс доорх төлөвүүдээр ялгаатай. Үүнд:

Үүрэг, зориулалтаар	Хэлний шинж, бүрдвэрээр
✓ Албан ёсны шинжтэй ✓ Өгүүлэл, илтгэл, сурах бичиг, ганц сэдэвт зохиол зэрэг маш өргөн хүрээг хамаардаг ✓ Мэдээлэх, нөлөөлөх зорилготой ✓ Нотолгоо, баримт, судалгааг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах, мэдээлэх үүрэгтэй ✓ Үнэнийг итгүүлэх, батлан нотлох арга хэрэглүүрийг чухалчилдаг. ✓ Утга санаа тодорхой, нэгтгэн дүгнэсэн байдаг,	✓ Хэлний уран дүрслэл, яруу хэрэглүүр багатай ✓ Давтамж ихтэй үг хэллэг хэрэглэгддэг ✓ Нийлмэл, урт өгүүлбэртэй ✓ Ярианы найруулгын үг бараг орохгүй ✓ Учир шалтгааны ухагдахуун, хийсвэр ойлголт голлодог ✓ Үгийн сангийн хувьд мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо их хэрэглэдэг, ✓ Мэргэжлийн шинж чанартай, шинжлэх ухааны хэлээр бичигддэг

Уран зохиолын төрлийн хэлний найруулгад сонирхолтой, яруу сонсголонтой, гоо зүйн хэм хэмжээг харгалзах шаардлагатай бол эрдэм шинжилгээний найруулгад товч тодорхой, оновчтой, эмх цэгцтэй, энгийн ойлгомжтой байх шаардлага голлоно.

Гурав. Эрдэм шинжилгээний найруулгын шаардлагыг харгалзах нь

Нэг. Агуулгын шаардлага:

А. Учир шалтгааны дараалалтай байх шаардлага: Энэ нь уг бүтээл, зохиол доторх зүйл нарийн дэс дараалалтай байрласан, өөр хоорондоо утгын талаар нягт холбоотой байх шаардлага юм. *Учир нь шинжлэх ухаан өөрөө логик, учир шалтгааны хуулинд үндэслэдэг.*

Бүлгээс бүлэгт, зүйлээс зүйлд, цогцолбороос цогцолборт, өгүүлбэрээс өгүүлбэрт, шилжихэд утгын болон логикийн нарийн холбоо, дэс дараа чухал. Иймд эрдэм шинжилгээний бүтээлийн учир зүйн холбоог илэрхийлэх чухал хэрэгсэл бол холбоос үг хэрэглэх, өгүүлбэр зүйн хэрэгслийг онож ашиглах явдал мөн. Тухайлбал: холбоосууд нь санаа бодлын эмх цэгц, дарааллыг заасан (*юуны урьд, нэгдүгээрт, ингэхэд гм*), эсрэгцлийг болон зөрчлийн харьцаа заасан (*гэсэн хэдий ч, тийм боловч, чухам үүнээс гм*), шалтгаан үр дагаврын харилцаа заасан (*иймээс, үүний улмаас, үүнээс гадна гм*), нэг санаанаас нөгөөд шилжих (*дахин авч үзэх, зайлшгүй нягтлах г.м.*), дүгнэлт хийхэд хэрэглэх (*эцэст нь дурдахад, эцэст нь дүгнэхэд гм*) маш олон ялгаагаар хэрэглэгддэг учир шалтгаанг мэдэж хэрэглэх нь чухал.

Б. Логикийн хуулиудад нийцэх шаардлага :

Үүнийг нарийн мэдэх нь, эргэлзээгүй оновчтой агуулгаар найруулахад чухал. *Логикийн хуулиуд нь зөв сэтгэхүйн чухал шинжүүд болох тодорхой, зөрчилгүй, тууштай, үндэслэлтэй байх зарчмуудыг чухалчилдаг.*

Логикийн эдгээр хуулийг эрдэм шинжилгээний бүтээл бичих хүн сайн мэдэж байх хэрэгтэй. Аливаа ойлголтын үнэн ба худлыг логик мөрдлөгөөр гаргадаг. Логикийн ухаанд үнэн худал гэсэн хоёр гаргалгаа, үнэний тухай нэг мөрдөлгөө бий тул зөрчвөл ойлголтын зөрөө, зөрчилт бодомж үүсч, логикийн буюу учирзүйн алдаанд хүрнэ.

Адилтгалын хууль нь янз бүрийн бодлуудыг адилтгаж болохгүй, бас адилхан бодлуудыг өөр өөр утгаар авч үзэж болохгүй гэсэн чухал шаардлагыг хангах учиртай байна.

Зөрчилгүй хуулийг ухамсартай хэрэглэх нь өөрийнхөө болоод бусдын санаа бодол дахь зөрчлийг бүрэн илрүүлж арилгах, сэтгэлгээн дэх бүх төрлийн алдаа ба авцалдаагүй байдалд бодитой хандахад тусалдаг онцлогтой.

Үгүйсгэх хууль нь зөрчилт хоёр бодомж нэг зэрэг худал байж чадахгүй, нэг нь үнэн нөгөө нь худал байна. Энэ хууль нь асуудалд тууштай хандахад тусална.

Хангалттай үндэслэлийн хууль нь аливаа зөв бодол хангалттай үндэслэлтэй байдаг гэж томъёолдог. Иймд эрдэм шинжилгээний бүтээл үнэн зөв байхын тулд үндэслэлтэй байх ёстой байна.

Тодорхой байх шаардлага. Энэ нь аливаа эх бичвэр уншихад ойлгомжтой, тодорхой байх шаардлага юм. Тодорхой байх шаардлагад

товч байх шаардлага мөн хамаарна. Эрдэм шинжилгээний зохиолын найруулгад харшилдаг, түгээмэл нэг алдаа нь нуршуу бичих, товч бус байх явдал юм.

Оновчтой байх шаардлага. Энэ шаардлагын гол нь, илэрхийлэх гэсэн санаагаа цөөн үгээр, онож илэрхийлэхэд оршдог. Аливаа найруулгын амин сүнс нь үгийг онож сонгох явдал байдаг. Үгийг онож сонгоогүйгээс найруулгын алдаа ялангуяа үг, нөхцөл илүүдсэн алдаа үүсдэг. Үг цөөн тусмаа утга гүнзгий, оновчтой болдог. Оновчтой байх шаардлага нь үнэн зөв байх зарчимд үндэслэнэ.

Иймд дүрэм, тодорхойлолт, ухагдахуун, дүгнэлт, хууль категори, зүй тогтол, ангилал, бүдүүвч хүснэгт, тоо баримт, мэдээлэл зэрэг нь шууд утгатай, үнэн зөв байх ёстой. Шинжлэх ухааны тогтсон нэр томьёог шинжлэх ухааны бүх зохиолд адил, тогтсон нэг утгаар хэрэглэх учиртай. Хуучирсан, зөрчилтэй гэж үзээд шинээр дэвшүүлж байгаа нэр томьёог үнэн зөв, баталгаа үндэслэлтэйгээр оруулж ирвэл бас нээлттэй.

Шинжлэх ухааны зохиолын найруулга оновчтой, ойлгомжтой энгийн байх шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд хэрэглэх үгээ зөв сонгон авах хэрэгтэй. Үүний тулд, ойролцоо утгатай олон үгээс илэрхийлэх санаагаа хамгийн оновчтой, ойлгомжтой гаргаж чадах үгийг нь сонгож, хэлзүйгээр зөв хэлбэржүүлэн өгүүлбэрт зохистой байрлуулах явдал тус болно.

Эрдэм шинжилгээний бүтээлд хэл найруулгын аливаа алдаа гаргахыг эрс хориглох тул алдаанаас сэргийлэх нь нэн эрхэм. Хэл найруулгын ялимгүй алдаа ч эрдмийн бүтээлийн үнэн зөв, үнэ цэнэтэй байхад харшилна. Хэлний хэм хэмжээ, найруулгын шаардлагыг хангаагүйгээс хэл найруулгад алдаа гардаг. Тухайлбал, үг буруу сонгосон, үг илүүдүүлж дутаасан, яруу хэрэглүүр оновчгүй хэрэглэсэн, нэг үгийг нуршин давтсан, үгийн өнгө аяс гажуудуулсан бол найруулгын алдаа болно. Харин баримтын болоод учир зүй, гоо зүйн алдаа гаргасан бол найруулгын бус алдаа болно.

Өгүүлэл, илтгэлийн нэр хэт сунжруу урт, ойлгомж муутай, үгчилсэн орчуулгын шинжтэй байх нь алдаанд тооцогдох тул аливаа ном, бүтээлийн нэр товч, тодорхой, үндсэн агуулгадаа тохирсон байх ёстой.

Найруулгын алдаанаас сэргийлэх гол арга бол бичсэн зүйлээ дахин дахин уншиж нягтлах, оновчтой сонголтууд хийх, хэлний

салбаруудын онцлогийг сайтар харгалзах явдал мөн.

Дөрөв. Эрдэм шинжилгээний найруулгад үгийн сан, хэлзүйн онцлогийг харгалзах нь

А. Үгийн сангийн хүрээнд харгалзах зүйл:

- Шинжлэх ухааны зохиолд нарийн мэргэжлийн үг хэллэг нэр томьёо түгээмэл боловч давтамж ихтэй хэрэглэгддэг.
- Нэр томьёо нь голцуу нэрээр бүтсэн дан ба нийлмэл үгээс, мөн өгүүлбэрээс бүтнэ. (*өгүүлэхүүн, арга зүй, авиа ондооших ёс гм*).
- Гадаад үгийг их хэрэглэнэ. (*мэргэжлийн дидактик, хэлний синтагм гм*).
- Шинжлэх ухааны зохиолд хэрэглэсэн зарим содон, оновчтой өгүүлбэр хэвшмэл хэллэг мэт хэрэглэгдэх нь бий. (*Үгийн өвгөн утгын таяг тулмой гм*)
- Эрдэм шинжилгээний хэл найруулгад уран сайхны үг, этгээд бүдүүлэг үг, хар ярианы үг төдийлэн ордоггүй. (*албан бичгийн найруулгатай адил*)
- Хийсвэр утгатай үг болон тоо баримт нэлээд хэрэглэнэ.
- Шинжлэх ухааны зохиолд тухайн санааг батлахын үүднээс бусдын зохиолоос эш авсан нь олонтаа тохиолддог. Жишээ нь, хэл шинжлэлч Т.Пагва “Зүрхэн тольтын тайлбар”-ыг судалсан тухай тэмдэглэлдээ «Юуны тул нөхцөл хэмээвээс, үсэг (авиа) хурж нэр үг болох, нэр үг хурж (өгүүлбэр) үг болох, үгсээр утгыг үзүүлэх бөлгөө. Утгыг үзүүлэх тэр цагт нөхцөл хэрэгтэй болой» Данзандагва хэмээх эшлэл авчээ.

Б. Үгзүйн хүрээнд харгалзах зүйл:

- Эрдэм шинжилгээний найруулгад хамгийн их хэрэглэгдэх нь нэр үг, тэмдэг нэр, үйл үг байдаг.
- Эрдэм шинжилгээний найруулгад нэр томьёо голлодог.
- Тийн ялгалын хэрэглээнээс олон тохиолдох нь харьяалах, нэрлэх заахын тийн ялгал байна.
- Үйл үг одоо цагийн хэлбэрээр голдуу тохиолддог.
- Нэгдүгээр биеийн “би” гэх төлөөний

үгийг ихэвчлэн “бид” хэмээн олон тооны хэлбэрээр бичдэг.

- Үйл үгээс нэр үг үүсгэх дагавар, олон тооны нөхцөл элбэг тохиолддог.
- Тоо баримт, тооцоо, цаг хугацаа чухал үүрэгтэй учраас тооны нэрийн бүх төрлийг өргөн хэрэглэнэ.
- Тэмдэг нэрээс чанарын харьцуулсан зэрэг их төлөв орно. (*“хамгийн, туйлын бага, маш их, үүнээс олон гм”*)
- Төлөөний үгээс “бид, тэд” зэрэг биеийн төлөөний нэр, “яагаад гэвэл, юу, хэзээ, хаана” гэх мэт асуух төлөөний нэр ихээхэн хэрэглэгдэнэ.
- Гадаад үгэнд монгол хэлний дагавар нөхцөл залган хэрэглэх тохиолдол бий. (*хими-ийн, технологи-ч, программ-ч-лал, механик-жс-уул-лт*)

В. Өгүүлбэрзүйн хүрээнд харгалзах зүйл:

- Эрдэм шинжилгээний найруулгад хүүрнэх аястай олон гишүүнт энгийн нийлмэл өгүүлбэр голлодог. Энэ нь логик бодомж ихтэй, ойлгоход төвөгтэй онолын үндэслэл, дүрэм теорем, магадлагаа, хийсвэр санааг илэрхийлэх нарийн нягт ойлголтууд байдагтай холбоотой. Гэхдээ хэт урт, нуршуу олон үгтэй байж бас болохгүй.
- Энгийн өгүүлбэрийн утга санаа дутмаг, бүрхэг, товч хураангуй байдаг тул эрдэм шинжилгээний найруулгад төдийлэн хэрэглэдэггүй.
- Эзэн биегүй өгүүлбэр их хэрэглэгддэг.
- Өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүд болон оруулсан үгийг нэлээд хэрэглэнэ.
- Хавсарсан нийлмэл өгүүлбэрийн гол өгүүлбэр нь биеэ даасан санааг заалгүй, харин тухайн хам сэдэвтэй нь холбох үүрэгтэй байдаг. Гол санаа нь гишүүн өгүүлбэртээ нэгдэж байдаг онцлогтой.
- Баталсан нотолсон, логик баталгаа бүхий хүүрнэх, захирах өгүүлбэр голлодог.

ДҮГНЭЛТ

Эрдэм шинжилгээний бүтээлийн хэлний гол асуудал найруулгадаа байдаг. Иймд эрдэм шинжилгээний зохиол бүтээлээ чанар чансаатай болгоё гэвэл дээр өгүүлсэн онол аргазүйн хэдэн зүйлийг оюутнууд судалгааны ажил, ангийн ажил, дипломын ажилдаа хэрэгжүүлэх, анх удаа дипломын ажил удирдаж байгаа залуу багш нар ч үүнд нь анхаарал тавибал сайн юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Баттогтох, Д. (2011). Эрдэм шинжилгээний найруулгын зарим асуудал, УБ.

Ванчигсүрэн, Д, Энхболд, В. (2001). Судалгаа шинжилгээний арга зүй, УБ.

Отгонсүрэн, Д. (1975). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар

Кедров, Б, М. (1985). Классификация наук, Москва

Оюун, Ц., (2012). *Орчин цагийн монгол хэл*. “Найруулга зүйн бүлэг”. МУБИС-ийн МОСС-ийн МХШ-ийн тэнхимийн бүтээл. Улаанбаатар

Оюун, Ц. (2015). Их, дээд сургуулийн үйл ажиллагааны онол арга зүй. Улаанбаатар

Оюун, Ц. (2007). Японы Токиогийн Гакүгэй их сургуулийн докторантуудад уншсан, “Монгол Улсын бүх шатны сургуульд баримталдаг сургалтын онол, арга зүйн чиглэл” сэдэвт лекц.

Сүхбаатар, Ц., нар. (1990). *Монгол хэлний найруулгын төрөл*. Улаанбаатар

Түмэндэмбэрэл, Д., Гита Штейнер Хамси., Оюун, Ц., Дуламрагчаа, Т. (2009). *Судалгаа хийх арга зүй -2*. Улаанбаатар